

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/88/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Назгүл Утас: 99427301 Цахим хаяг: NazgulD@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

**САГСАЙ СУМЫН ХҮҮХДИЙН 3 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
К.ЛИМАН ТАНАА**

2024.02.28 № 248
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагсай сумын Хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402300

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ЖАЙГУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

СТ-1А

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>30,284,898.68</u>	<u>104,151,329.70</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,462,878.68	90,897,770.66
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,462,878.68	90,897,770.66
3121	Төгрөг	9,462,878.68	90,897,770.66
31211	Төрийн сангийн харилцах	9,462,878.68	90,897,770.66
35	БАРАА МАТЕРИАЛ	20,822,020.00	13,253,559.04
354	Хангамжийн материал	20,822,020.00	13,253,559.04
35410	Бичиг хэргийн материал	352,000.00	-
35420	Аж ахуйн материал	14,061,550.00	12,424,300.00
35440	Түлш, шатах тослох материал	500.00	-
35460	Хүнсний материал	6,302,970.00	724,259.04
35470	Бусад хангамжийн материал	105,000.00	105,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>447,205,140.37</u>	<u>434,682,431.87</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	447,205,140.37	434,682,431.87
392	Биет хөрөнгө	447,205,140.37	433,259,192.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	436,440,530.00	436,440,530.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,581,351.20)	(21,922,026.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,771,613.00	9,777,613.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(434,774.27)	(887,871.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,989,573.00	12,444,573.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,980,450.16)	(2,593,625.20)
393	Биет бус хөрөнгө	-	1,423,239.00
39301	Програм хангамж	-	1,423,239.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>477,490,039.05</u>	<u>538,833,761.57</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>807,385.68</u>	<u>511,385.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	807,385.68	511,385.00
413	Өглөг	807,385.68	511,385.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	295,000.68	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	512,385.00	511,385.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>476,682,653.37</u>	<u>538,322,376.57</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	476,682,653.37	538,322,376.57
512	Хуримтлагдсан үр дүн	476,682,653.37	538,322,376.57
51210	Өмнөх үеийн үр дүн	-	476,682,653.37
51220	Тайлант үеийн үр дүн	476,682,653.37	61,639,723.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>477,490,039.05</u>	<u>538,833,761.57</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	267,303,376.00	382,048,339.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,387,976.00	364,219,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	48,387,976.00	364,219,100.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	48,387,976.00	364,219,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	48,387,976.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	5,779,239.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	218,915,400.00	17,829,239.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	185,878,700.00	5,779,239.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	185,878,700.00	364,219,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,933,200.00	12,050,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,933,200.00	12,050,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	203,681,427.07	310,787,782.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	203,681,427.07	310,787,782.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	203,006,312.07	310,787,782.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,163,506.32	217,914,767.30
210101	Үндсэн цалин	141,900,617.02	181,710,811.16
210102	Нэмэгдэл	1,340,900.00	23,254,776.14
210104	Урамшуулал	4,921,989.30	12,949,180.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,355,586.68	38,102,600.00
210201	Тэтгэврийн даатгал	12,316,900.00	26,012,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,569,900.00	2,909,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,256,000.00	2,447,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	612,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,212,786.68	6,120,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	197,960.00	-
210302	Түлш, халаалт	197,960.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	490,700.00	14,879,760.00
210401	Бичиг хэрэг	490,700.00	-
210402	Тээвэр, шатахуун	-	14,879,760.00
2105	Нормативт зардал	19,234,705.00	22,480,791.00
210502	Хоол, хүнс	19,234,705.00	22,480,791.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	100,000.00
210604	Урсгал засвар	-	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	820,000.00
210702	Дотоод албан томилолт	-	820,000.00

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	191,000.00	283,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	191,000.00	283,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,372,854.07	16,206,864.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,822,254.00	2,535,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	794,700.00	3,340,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,755,900.07	10,331,114.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	675,115.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	675,115.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	675,115.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	675,115.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>63,621,948.93</u>	<u>71,260,556.40</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	9,620,833.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	9,620,833.20
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(9,620,833.20)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>63,621,948.93</u>	<u>61,639,723.20</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>218,915,400.00</u>	<u>376,269,100.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>218,915,400.00</u>	<u>376,269,100.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	185,878,700.00	364,219,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	185,878,700.00	364,219,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,933,200.00	12,050,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,933,200.00	12,050,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>207,252,521.32</u>	<u>293,184,208.02</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>207,252,521.32</u>	<u>293,184,208.02</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>206,577,406.32</u>	<u>293,184,208.02</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,163,506.32	217,540,216.02
210101	Үндсэн цалин	132,549,986.80	181,336,259.88
210102	Нэмэгдэл	10,691,530.22	23,254,776.14
210104	Урамшуулал	4,921,989.30	12,949,180.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,282,500.00	38,772,152.00
210201	Тэтгэврийн даатгал	12,003,000.00	26,012,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,569,900.00	2,909,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,256,000.00	2,447,800.00

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгал	313,900.00	1,281,852.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,139,700.00	6,120,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,800,000.00	11,950,000.00
210301	Гэрэл, цахилгаан		1,650,000.00
210302	Түлш, халаалт	9,800,000.00	10,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	490,700.00	-
210401	Бичиг хэрэг	490,700.00	
2105	Нормативт зардал	21,495,100.00	16,858,000.00
210502	Хоол, хүнс	21,495,100.00	16,858,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	296,000.00	543,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	296,000.00	543,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,949,600.00	7,420,340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,390,300.00	5,789,940.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,559,300.00	1,630,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	675,115.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	675,115.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	675,115.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>11,662,878.68</u>	<u>83,084,891.98</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,200,000.00	1,650,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,200,000.00	1,650,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,200,000.00	1,650,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,200,000.00	1,650,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(2,200,000.00)</u>	<u>(1,650,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9,462,878.68	81,434,891.98
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,462,878.68
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,462,878.68	90,897,770.66

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээ-ний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			476,682,653.37		476,682,653.37
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	476,682,653.37	0.00	476,682,653.37
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	476,682,653.37	0.00	476,682,653.37
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	476,682,653.37	0.00	476,682,653.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	476,682,653.37	0.00	476,682,653.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			61,639,723.20		61,639,723.20
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	538,322,376.57	0.00	538,322,376.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,462,878.68
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	385,731,978.68	294,834,208.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	385,731,978.68	294,834,208.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,731,978.68	294,834,208.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,026,200.00	217,540,216.02
210101	Үндсэн цалин	191,669,700.00	181,336,259.88
210102	Нэмэгдэл	103,604,400.00	23,254,776.14
210104	Урамшуулал	12,752,100.00	12,949,180.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,503,600.00	38,772,152.00
210201	Тэтгэврийн даатгал	26,182,200.00	26,012,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,080,500.00	2,909,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,463,800.00	2,447,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	616,300.00	1,281,852.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,160,800.00	6,120,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,950,000.00	11,950,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,650,000.00	1,650,000.00
210302	Түлш, халаалт	10,300,000.00	10,300,000.00
2105	Нормативт зардал	17,434,500.00	16,858,000.00
210502	Хоол, хүнс	17,434,500.00	16,858,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	543,500.00	543,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	543,500.00	543,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,174,178.68	9,070,340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,543,778.68	7,439,940.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,630,400.00	1,630,400.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	376,269,100.00	376,269,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	364,219,100.00	364,219,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	364,219,100.00	364,219,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,050,000.00	12,050,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	12,050,000.00	12,050,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		9,462,878.68
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		90,897,770.66
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	20.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

620002	Гүйцэтгэх ажилтан	5.00	5.00
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	50.00	50.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	50.00	50.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	50.00	50.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Цэцэрлэг нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан цэцэрлэгийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах” зорилгын хүрээнд “Ээлжит хичээлийг чанаржуулах”, “Хүүхдийн насны онцлогт тохируулан хөгжүүлж, эрүүл сааруул эсэн мэнд асран хамгаалж хүүхдийн хөгжлийг дэмжин нийгэмшүүлж бие хүн болгон төлөвшүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузал суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61.3 сая төгрөгөөр буюу 12.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,462.88	90,897.77	81,434.89
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	20,822.02	13,253.56	(7,568.46)
Үндсэн хөрөнгө	447,205.14	434,682.43	(12,522.71)
Нийт хөрөнгө	477,490.04	538,833.76	61,343.72
Өр төлбөр	807.39	511.39	(296.00)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	476,682.65	538,322.38	61,639.72
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	477,490.04	538,833.76	61,343.72

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцэст 90.9 сая төгрөг болж оны эхнээс 81.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний 90.2 сая төгрөг нь цалин, 0.6 сая төгрөг нь хүүхдийн хоолны зардал, 0.1 сая төгрөг нь бусад зардлын төсвөөс үлдсэн мөнгө байна.

Бараа материал дансны үлдэгдэл оны эцэст 13.2 сая төгрөг болж 7.6 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: аж ахуйн материалын үлдэгдэл 12.4 сая, хүнсний материал 0.7 сая, бусад хангамжийн материал 0.1 сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 454.6 сая төгрөг болж 12.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1.6 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 4.4 сая, нийт 6.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, 11.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн, 10.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Оны эхэнд 0.8 сая төгрөгийн өглөгтэй байсан ба тайлант хугацаанд 0.5 сая төгрөг болж, 0.3 сая төгрөгөөр буурсан байна. Уг өглөг нь бусад байгууллагад төлөх хоолны өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 538.3 сая төгрөг болж 61.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 61.6 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 370.5 сая, орон нутгийн төсвөөс 14.7 сая, нийт зарлагыг 385.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 364.2 сая төгрөгөөр хянаж, 6.3 сая төгрөгөөр бууруулж баталсан ба төсвийн тодотголоор 9.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 373.7 сая төгрөг болгон тодотгож баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 12.0 сая төгрөгөөр баталж, тодотголоор өөрчлөлт оруулаагүй байна.

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 373.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 12.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 385.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 373.7 сая, орон нутгийн төсвөөс 12.0 сая нийтдээ 385.7 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Үүний 9.5 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 294.8 сая төгрөг / 76.4 хувьтай / буюу дансанд 90.9 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605	Эрүүл мэндийг дэмжих	815.2	815.2	0	100%
2	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	17,434.5	16,858.0	576.5	96.7%
3	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	815.2	815.2	0	100%
4	81834	Боловсролын стандарт, сургалтын	166,337.8	134,514.0	31,823.8	80.9%
5	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	186,626.9	128,129.4	58,497.5	68.7%
6	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	12,050.0	12,050.0	-	100%
7	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	17,434.5	16,858.0	576.5	96.7%
Нийт дүн			385,732.0	294,834.2	90,897.8	76.4

Цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 90.9 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалингийн зардал 90.2 сая, хоолны норматив зардал 0.6 сая, бараа үйлчилгээний бусад зардал 0.1 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 34.9 сая төгрөгийн бараа материал, 1.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, нийт 36.6 сая төгрөгийн эд хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний аудитор В.Хуандаг хийж, анхан шатны хяналтыг “Уужим алтай Аудит” ХХК-ний захирал Б.Галымбек гүйцэтгэж, дараагийн шатны хяналтыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Уужим Алтай Аудит ХХК”-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/33 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 210.5 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 3.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллааа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын FAS программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг шалгахад 376.3 сая төгрөгийн орлогын гүйлгээг шилэн дансанд бүрэн мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5.1 сая төгрөгийн зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 81.3%-тай байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн төсөв, өмч, хөрөнгө зарцуулахтай холбоотой албан хаагчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт олгох, балансын урамшуулал олгох тухай 12.1 сая төгрөгийн 2 тушаал гарсан ба уг тушаалын гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....” заасны дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг шалгах шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар Сагсай сумын ахлах сургуульд шилжүүлсэн 9.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үндсэн хөрөнгө худалдсаны гарзыг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаагүй алдааг илрүүлж, аудитын явцад залруулга хийлгэсэн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт өгөгдөөгүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар цалингийн зардлаас ажилтнуудад 11.0 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын тодруулга тайланд тусгасан бараа материалын зарцуулалтыг нярвын тайлантай тулгахад орлого, зарлагын дүн 1.4 сая төгрөгөөр зөрүүтэй, нярав нь бараа материалын зарлагатай холбоотой анхан шатны баримтыг үндэслэж бараа материалын тайланг үнэн зөв гаргаагүй, шатахууны зарцуулалтын анхан шатны баримтыг баримтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, заавартай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.7 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж, бараа материалын тайланг үнэн, зөв гаргах, илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилжүүлсэн үндсэн хөрөнгийн гарзыг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаагүй, тайлант оны үр дүнг буруу тооцоолсон	1	9,620.8					1	9,620.8				
Дүн	1	9,620.8					1	9,620.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	11,000.0					1	11,000.0				
Бараа материалын нярвын тайланг журмын дагуу бэлтгэж, тайлагнаагүй	1	1,435.0					1	1,435.0				
Дүн	2	12,435.0					2	12,435.0				

Сагсай сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан шийдвэрийг шилэн дансанд байршуулаагүй	1	12,053.0					1	12,053.0
	1	12,053.0					1	12,053.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								